

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/002/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn
Говьсүмбэр аймаг
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: nananbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа
Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2026.03.25 № 55
танай _____ -ны № _____ -т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Т.БАЯСГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4226050247

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,424,361,729.85	9,396,517,235.14
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,028,083,401.60	2,654,140,037.88
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	3,028,083,401.60	2,654,140,037.88
31210	1.1.1.02.01 Төгрөг	3,028,083,401.60	2,654,140,037.88
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	3,028,083,401.60	2,654,140,037.88
33	1.1.3 АВЛАГА	6,396,278,328.25	6,742,377,197.26
33300	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	455,927,064.15	455,877,491.15
33402	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	5,816,419,981.12	6,107,430,050.89
33500	1.1.3.07 Бусад авлага	123,931,282.98	179,069,655.22
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	22,061,745.45	28,646,371.89
33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	101,869,537.53	150,423,283.33
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	9,424,361,729.85	9,396,517,235.14
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	451,293,663.92	645,668,259.30
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	451,293,663.92	645,668,259.30
41300	2.1.1.03 Өглөг	246,788,204.34	347,091,898.16
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	246,788,204.34	347,091,898.16
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	24,892,467.99	26,898,935.24
41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	221,234,086.35	320,192,962.92
41366	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	661,650.00	-
41400	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	204,505,459.58	298,576,361.14
41410	2.1.1.04.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	204,505,459.58	298,576,361.14
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,973,068,065.93	8,750,848,975.84
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	8,973,068,065.93	8,750,848,975.84
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	8,973,068,065.93	8,750,848,975.84
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	10,516,695,687.25	8,930,620,345.81
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	(1,543,627,621.32)	(179,771,369.97)
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	9,424,361,729.85	9,396,517,235.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	52,244,811,710.19	60,892,172,040.00
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	23,545,037,382.35	27,520,880,478.35
112	1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	23,545,037,382.35	27,520,880,478.35
1122	1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,215,347,850.98	22,419,718,749.44
112001	1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	19,215,347,850.98	22,419,718,749.44
112002	1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	2,045,138,713.97	2,412,384,623.06
112003	1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	1,569,559,871.31	1,849,009,147.67
112004	1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	714,990,946.09	839,767,958.18
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,250,494.51	33,371,291,561.65
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	125,250,494.51	101,275,951.65
1201	1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	21,606,652.38	35,546,414.46
120002	1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	21,606,652.38	35,546,414.46
120003	1.1.1.04.1.03 Торгуулийн орлого	-	521,250.00
120009	1.1.1.04.1.09 Бусад орлого	103,643,842.13	65,208,287.19
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	33,270,015,610.00
1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	33,270,015,610.00
12215	1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	-	5,693,046,960.00
122152	1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	5,693,046,960.00
122004	1.1.1.04.3.01.07НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого	-	27,576,968,650.00
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,574,523,833.33	-
1310	1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	4,943,132,033.33	-
131001	1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,943,132,033.33	-
1330	1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	23,631,391,800.00	-
133002	1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	23,631,391,800.00	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	53,788,439,331.51	61,071,943,409.97
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	53,788,439,331.51	61,071,943,409.97
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,530,710.00	8,171,370.00
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,530,710.00	8,171,370.00
210801	1.1.2.01.1.08.01Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,533,300.00	6,200,600.00
210808	1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	997,410.00	1,970,770.00
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,779,908,621.51	61,063,772,039.97
2131	1.1.2.01.4.01Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	27,317,435,834.51

21311	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	27,317,435,834.51
213104	1.1.2.01.4.01.01.05 НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	27,317,435,834.51
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	29,307,836,102.69	33,746,336,205.46
213202	1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	29,307,836,102.69	33,746,336,205.46
2135	1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,472,072,518.82	-
213503	1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	24,472,072,518.82	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(1,543,627,621.32)	(179,771,369.97)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(1,543,627,621.32)	(179,771,369.97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	58,013,122,045.85	65,814,798,307.52
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	29,438,945,374.59	27,332,054,985.21
112	1.1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	29,438,945,374.59	27,332,054,985.21
1122	1.1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	19,647,144,760.82	22,288,820,563.02
112001	1.1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	19,647,144,760.82	22,288,820,563.02
112002	1.1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	2,070,097,805.16	2,386,736,071.09
112003	1.1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	2,833,936,882.09	1,827,712,071.74
112004	1.1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	562,879,497.67	828,786,279.36
1121	1.1.1.1.03.2.05 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	4,324,886,428.85	-
112005	1.1.1.1.03.2.05.05 Бусад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого	4,324,886,428.85	-
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,695,271.26	38,482,743,322.31
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	57,695,271.26	5,210,926,672.31
1201	1.1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	21,821,939.50	35,593,806.23
120002	1.1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	21,821,939.50	35,593,806.23
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	35,873,331.76	5,175,332,866.08

122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	33,271,816,650.00
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	33,271,816,650.00
12215	1.1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив,тусламж	-	5,694,848,000.00
122152	1.1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	5,694,848,000.00
122004	1.1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	27,576,968,650.00
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,516,481,400.00	-
1310	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	4,885,089,600.00	-
131001	1.1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,885,089,600.00	-
1330	1.1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	23,631,391,800.00	-
133002	1.1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	23,631,391,800.00	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,202,440,395.38	66,188,741,671.24
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	58,202,440,395.38	66,188,741,671.24
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,171,803.02	32,338,124.99
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,530,710.00	8,171,370.00
210801	1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,533,300.00	6,200,600.00
210808	1.1.1.2.01.1.08.02 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	997,410.00	1,970,770.00
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	30,641,093.02	24,166,754.99
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	30,641,093.02	24,166,754.99
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,163,268,592.36	66,156,403,546.25
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	32,489,055,328.04
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	32,489,055,328.04
213104	1.1.1.2.01.4.01.01.5 НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	32,489,055,328.04
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	29,121,621,987.56	33,667,348,218.21
213202	1.1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	29,121,621,987.56	33,667,348,218.21

2135	1.1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,041,646,604.80	-
213503	1.1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	29,041,646,604.80	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(189,318,349.53)	(373,943,363.72)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(189,318,349.53)	(373,943,363.72)
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,217,401,751.13	3,028,083,401.60
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,028,083,401.60	2,654,140,037.88
100	3 Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	11,698,398,843.33	11,698,398,843.33
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,181,703,156.08)	(1,181,703,156.08)
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	10,516,695,687.25	10,516,695,687.25
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	(1,543,627,621.32)	(1,543,627,621.32)
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,973,068,065.93	8,973,068,065.93
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	8,973,068,065.93	8,973,068,065.93
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(42,447,720.12)	(42,447,720.12)
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,930,620,345.81	8,930,620,345.81
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	(179,771,369.97)	(179,771,369.97)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	8,750,848,975.84	8,750,848,975.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	12. Зөрүү
1	3.1.01.1 НИИТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО ТУСЛАМЖИЙН ДҮН БА	36,466,925,600.00	33,100,051,998.54	3,366,873,601.46
11	3.1.01.1.1 Татварын орлого	30,772,077,600.00	27,405,203,998.54	3,366,873,601.46
112	3.1.01.1.1.2 Нийгмийн даатгалын орлого	30,772,077,600.00	27,405,203,998.54	3,366,873,601.46
112001	3.1.01.1.1.2.1 Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,832,667,600.00	22,342,896,964.58	3,489,770,635.42
112002	3.1.01.1.1.2.2 Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,283,507,100.00	2,392,810,792.80	(109,303,692.80)
112003	3.1.01.1.1.2.3 ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,718,286,400.00	1,830,839,716.71	(112,553,316.71)
112004	3.1.01.1.1.2.4 Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	937,616,500.00	838,656,524.45	98,959,975.55
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	5,694,848,000.00	5,694,848,000.00	-
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	5,694,848,000.00	5,694,848,000.00	-
122001	3.1.01.1.2.3.1 Хандив тусламж /дотоод/	5,694,848,000.00	5,694,848,000.00	-
II	3.1.01.2 НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,134,678,800.00	33,675,519,588.21	459,159,211.79
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	34,134,678,800.00	33,675,519,588.21	459,159,211.79
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,510,700.00	8,171,370.00	339,330.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,510,700.00	8,171,370.00	339,330.00
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,200,600.00	6,200,600.00	-
210808	3.1.01.2.1.1.8.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,310,100.00	1,970,770.00	339,330.00
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,126,168,100.00	33,667,348,218.21	458,819,881.79
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	34,126,168,100.00	33,667,348,218.21	458,819,881.79
213202	3.1.01.2.1.4.2.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	34,126,168,100.00	33,667,348,218.21	458,819,881.79
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ	2,332,246,800.00	(575,467,589.67)	1,756,779,210.33
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮҮСВЭР ЭХ	2,332,246,800.00	(575,467,589.67)	1,756,779,210.33
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,332,246,800.00	(575,467,589.67)	1,756,779,210.33
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,028,083,401.60	3,028,083,401.60
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,452,615,811.93	2,452,615,811.93

3. Аудитын илрүүлэлт:

Завсрын аудитаар:

Завсрын аудит хийгээгүй байна.

3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "Төсөв гүйцэтгэл" цэст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24,595.0 сая төгрөгийн орлогын, 24,726.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.5, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 дахь заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг тухай бүрд нь түргэн шуурхай мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4. Аудитаар 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 1 алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 1, 2 дугаар хавсралтын дагуу иж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүрэн бэлтгэж санхүүгийн тайлан ирүүлээгүй / тодруулга, тооцоо нийлсэн актууд / нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Залруулаагүй алдаа:

Байхгүй.

Аудитаар нийт 290.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 290.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 290.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

4.1 Төлбөрийн акт

Байхгүй.

4.2 Албан шаардлага

Байхгүй.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг ТББ нь Сүмбэр сумын 5 дугаар багийн "Хөдөөгийн баясгалан" өдөрлөгт оролцож малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарт "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ҮОМШӨ урьдчилан сэргийлэх" сургалтыг зохион байгуулсан. Нийт 45 малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг хамруулсан гэх боловч сургалтын хамрагдалт хангалтгүй /зөвхөн 1 багийн малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч/, зохион байгуулалт муутай, үр дүнгүй, бодит гүйцэтгэлд үндэслэн гэрээг дүгнээгүй, 2.1 сая төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх сургалтад хамрагдалтыг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, үр дүн сайжруулах, сургалтын хамрагдалт, чанар, үр дүнд үндэслэн гэрээ дүгнэх

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Олон жилийн насжилттай /1-5 жил/ найдваргүй болох эрсдэлтэй 13 ААНБ-аас авах нийт 288.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тайлант онд хууль хяналтын байгууллагад хандан арга хэмжээ авч ажилласан боловч тайлант онд дорвитой барагдуулаагүй /13 ААНБ/ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Олон жилийн насжилттай, найдваргүй болох эрсдэлтэй, иргэн, ААНБ-аас авах авлагыг тодорхой хэмжээнд бууруулж ажиллах

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сан	1	0.0			1	0.0	1	0.0				
Дүн	1	0.0			1	0.0	1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сан	2	290.7					2	290.7				
Дүн	2	290.7					2	290.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сан	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0.0					1	0.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			